



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 5/26

Улаанбаатар хот

Б.Даваадолгорт цалинтай чөлөө,
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.19.1, 7.3.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтсийн Сүлжээ төлөвлөлтийн мэргэжилтэн Батбаатар овогтой Даваадолгорын ар гэрт гачигдал гарч хөдөө орон нутагт зорчих хүндэтгэх шалтгааныг харгалзан үзэж, 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 5 өдрийн цалинтай чөлөө, нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн зардал 100,000 төгрөг /нэг зуун мянга/-ийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Даваадолгорын албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч /С.Цэцэгмаа/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР